



“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/21 тоот тогтоолын  
1 дугаар хавсралтаар батлав

## **“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү “Инновэйшн Инвестмент” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Залгамж халааны бодлогын баримт бичиг (цаашид "Баримт бичиг" гэх)-ийн зорилго нь Компанийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү баримт бичгийн зорилт нь Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодын гишүүд болон гүйцэтгэх захирлын залгамж халааг төлөвлөхөд оршино.
- 1.3. Компани нь Баримт бичгийг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журам, Компанийн засаглалын кодекс болон холбогдох бусад хууль, тогтоомжийг баримтална.

### **Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид “Хороо” гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 2.2. Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.4. Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.5. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

### **Гурав. Залгамж халааг бэлтгэх журам**

- 3.1. ТУЗ-ийн залгамж халааны төлөвлөлт:

- 3.1.1. Хороо нь ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн эзлэх хувь 1/3 доошгүй байхыг эрмэлзэнэ.
- 3.1.2. Хороо нь ТУЗ-ийн гишүүний бүрэлдэхүүнд хараат болон хараат бус гишүүний тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино.
- 3.1.3. Хороо нь ТУЗ-ийн гишүүнд тохирох мэдлэг, чадвар, туршлагатай хүнийг олж тодорхойлно.
- 3.1.4. Хороо нь ТУЗ-ийн гишүүнд шинээр эсхүл улираан томилохоор төлөвлөж буй хүнийг тухайн ажлын байранд тохирч буй эсэхийг нягталсны үндсэн дээр тодорхойлно.
- 3.2. Гэнэтийн нөхцөлд авах арга хэмжээ: ТУЗ-ийн гишүүн гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн бол Хороо яаралтай хуралдаж, орлон ажиллах этгээдийг тодорхойлж, зохих журмын дагуу ТУЗ-д санал болгож, томилгоог процессын дагуу хийлгүүлнэ.

#### **Дөрөв. Бусад**

- 4.1. Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

### **“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК**

---oOo---

УЛААНБААТАР ХОТ

**ИННОВЭЙШН  
ИНВЕСТМЕНТ  
ХК**

ШТШ 867 6183948 9024070240



**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/21

Улаанбаатар хот

**ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 9.6.17 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Инновэйшн Инвестмент ХК-ийн “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт-1 ёсоор баталсугай.
2. Батлагдсан баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

